

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/236-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2023 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-16
4. Аудитын тайлан	17-17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17-18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕП	Монгол Улсын Ерөнхий прокурор
МУПЕГ	Монгол Улсын Прокурорын Ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-02-14 № 109-2023/236-НА-СТА-ТШЗ

тантай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Прокурорын газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 95.0 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл, урамшлын зардлыг 2.2 хувиар, НДШ-ийн зардлыг 5.4 хувиар, тогтмол зардлыг 6.5 хувиар, хангамж, бараа материалын зардлыг 6.1 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж нийт төсөв 5.0 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Прокурорын газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 82.5 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд хангамж, бараа материалын зардалд 34,010.6

мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 33,537.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 28,998.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

МУЕП-ын 2022 оны А/118 дугаар тушаалын дагуу батлагдсан цалингийн зардлын 3.0 хувь болох 15,818.0 мянган төгрөгийг МУЕПГ-ын "Ахмадын сан-гийн дансанд шилжүүлж, төсөвт тусгагдаагүй зардал гаргасан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,903,043.61	20,500,612.61
35	БАРАА МАТЕРИАЛ	17,903,043.61	20,500,612.61
354	Хангамжийн материал	17,903,043.61	20,500,612.61
35410	Бичиг хэргийн материал	3,057,838.00	2,682,650.00
35420	Аж ахуйн материал	4,895,800.00	10,179,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,186,400.00	1,800,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,256,205.61	69,462.61
35450	Барилгын засварын материал	00.00	40,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,506,800.00	5,728,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	814,061,289.34	835,214,842.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	814,061,289.34	835,214,842.35
392	Биет хөрөнгө	810,161,289.34	830,187,342.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	669,602,340.00	669,602,340.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-33,555,073.68	-44,740,098.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,700,000.00	75,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-81,910,416.75	-27,152,083.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,077,042.76	147,382,290.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,382,296.71	-43,160,774.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,140,368.81	81,403,068.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,519,675.09	-28,956,400.85
39217	Ном	9,000.00	9,000.00
393	Биет бус хөрөнгө	3,900,000.00	5,027,500.00
39301	Програм хангамж	550,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-192,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,900,000.00	3,900,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	831,964,332.95	855,715,454.96
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	831,964,332.95	855,715,454.96
51	Засгийн газрын хувь оролцоо	831,964,332.95	855,715,454.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	275,943,025.00	275,943,025.00
51101	Өмч: - төрийн	275,943,025.00	275,943,025.00
512	Хуримтлагдсан үр дүн	525,991,114.43	549,742,236.44
51210	Өмнөх үеийн үр дүн	525,991,114.43	525,991,114.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	23,751,122.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,030,193.52	30,030,193.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	831,964,332.95	855,715,454.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Амжилт
МАНГАЙ
А
/төгрөгөөр/
4317143998
9055436

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	803,362,188.00	796,467,350.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,605,488.00	58,761,150.00
120	Нийтлэг татварын бус орлого	51,605,488.00	58,761,150.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51,605,488.00	58,761,150.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	751,756,700.00	737,706,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	751,756,700.00	737,706,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	751,756,700.00	737,706,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	688,855,384.36	772,716,227.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	688,855,384.36	772,716,227.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	688,855,384.36	734,156,696.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	461,786,165.64	515,785,029.82
210101	Үндсэн цалин	243,506,107.16	313,548,560.56
210102	Нэмэгдэл	190,550,327.85	153,640,967.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,929,730.63	23,205,000.00
210104	Урамшуулал	00.00	25,390,501.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,674,131.80	62,334,620.36
210201	Тэтгэврийн даатгал	40,703,759.73	44,367,663.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,519,693.12	4,505,587.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,588,874.35	3,601,110.09
210204	Ажилгүйдлийн даатгал	889,618.66	896,387.19
210205	Эрүүл мэндийн даатгал	8,972,185.94	8,963,871.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,448,150.37	28,998,145.57
210301	Гэрэл, цахилгаан	7,095,008.37	6,619,983.57
210302	Түлш, халаалт	22,723,406.00	18,127,784.00
210303	Цэвэр, бохир ус	8,629,736.00	4,250,378.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,520,234.00	36,280,101.00
210401	Бичиг хэрэг	8,295,580.00	12,402,738.00
210402	Тээвэр, шатахуун	4,088,202.00	11,586,343.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,296,722.00	4,391,570.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	951,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,737,430.00	6,948,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,405,000.00	14,008,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	298,900.00
210604	Урсгал засвар	44,405,000.00	13,709,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,113,100.00	4,953,800.00
210702	Дотоод албан томилолт	3,113,100.00	4,953,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,738,000.00	9,597,453.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,844,300.00	8,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,000.00	188,853.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	396,000.00	1,356,800.00
210807	Газрын төлбөр	3,900.00	7,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,170,602.55	62,199,246.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,492,000.00	4,335,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,480,000.00	561,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,198,602.55	57,302,196.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	38,559,531.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,210,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,210,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	37,349,531.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	37,349,531.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>114,506,803.64</u>	<u>23,751,122.01</u>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		
225006	Гадаадын төслийн зээлээс санхүүжих дамжуулан зээлдүүлэх		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>114,506,803.64</u>	<u>23,751,122.01</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	751,756,700.00	737,706,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	751,756,700.00	737,706,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	751,756,700.00	737,706,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	751,756,700.00	737,706,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	717,276,500.00	718,011,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	717,276,500.00	718,011,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	694,014,127.81	679,452,068.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	461,786,165.64	515,785,029.82
210101	Үндсэн цалин	270,427,472.42	314,161,238.77
210102	Нэмэгдэл	164,511,820.67	153,505,937.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,046,872.55	22,804,658.67
210104	Урамшуулал	00.00	25,313,194.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,674,131.80	62,334,620.36
210201	Тэтгэврийн даатгал	40,703,759.78	42,492,404.32
210202	Тэтгэмжийн даатгал	4,519,693.11	4,974,402.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,588,874.34	3,976,162.00
210204	Ажилгүйдлийн даатгал	889,618.66	990,150.18
210205	Эрүүл мэндийн даатгал	8,972,185.91	9,901,501.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,448,150.37	28,998,145.57
210301	Гэрэл, цахилгаан	7,095,008.37	6,619,983.57
210302	Түлш, халаалт	22,723,406.00	18,127,784.00
210303	Цэвэр, бохир ус	8,629,736.00	4,250,378.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,250,680.00	34,010,570.00
210401	Бичиг хэрэг	12,474,728.00	11,895,750.00
210402	Тээвэр, шатахуун	8,350,000.00	9,399,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,515,062.00	4,391,570.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	951,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,501,690.00	7,372,650.00
2105	Нормативт зардал	00.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,783,400.00	13,842,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	519,800.00	298,900.00
210604	Урсгал засвар	52,263,600.00	13,544,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,113,100.00	4,953,800.00
210702	Дотоод албан томилолт	3,113,100.00	4,953,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,883,100.00	9,440,653.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,989,400.00	8,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,000.00	188,853.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	396,000.00	1,200,000.00
210807	Газрын төлбөр	3,900.00	7,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,075,400.00	8,586,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,184,400.00	8,586,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,262,372.19	38,559,531.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,210,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,210,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,262,372.19	37,349,531.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,262,372.19	37,349,531.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	34,480,200.00	19,694,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,480,200.00	19,694,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,480,200.00	19,694,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,480,200.00	19,694,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,480,200.00	19,694,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-34,480,200.00	-19,694,600.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	275,943,025.00	30,030,193.52	472,713,192.71	778,686,411.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,943,025.00	30,030,193.52	472,713,192.71	778,686,411.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	114,506,803.64	114,506,803.64
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,943,025.00	30,030,193.52	525,991,114.43	831,964,332.95
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	275,943,025.00	30,030,193.52	525,991,114.43	831,964,332.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,943,025.00	30,030,193.52	525,991,114.43	831,964,332.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	23,751,122.01	23,751,122.01
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,943,025.00	30,030,193.52	549,742,236.44	855,715,454.96

/төгрөгөөр/

143998
MCA0065905-36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/
 4317143998
 M-QA0065 0055436


Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	737,706,200.00	700,356,668.75	37,349,531.25	94.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	737,706,200.00	700,356,668.75	37,349,531.25	94.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	735,446,200.00	699,146,668.75	36,299,531.25	95.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,274,400.00	515,785,029.82	11,489,370.18	97.8
210101	Үндсэн цалин	297,587,600.00	314,161,238.77	-16,573,638.77	105.6
210102	Нэмэгдэл	182,706,200.00	153,505,937.54	29,200,262.46	84.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,319,600.00	22,804,658.67	6,514,941.33	77.8
210104	Урамшуулал	17,661,000.00	25,313,194.84	-7,652,194.84	143.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,909,400.00	62,334,620.36	3,574,779.64	94.6
210201	Тэтгэврийн даатгал	45,617,000.00	42,492,404.32	3,124,595.68	93.2
210202	Тэтгэмжийн даатгал	5,073,100.00	4,974,402.60	98,697.40	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,058,500.00	3,976,162.00	82,338.00	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,014,600.00	990,150.18	24,449.82	97.6
210205	Эрүүл мэндийн даатгал	10,146,200.00	9,901,501.26	244,698.74	97.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,012,900.00	28,998,145.57	2,014,754.43	93.5
210301	Гэрэл, цахилгаан	6,138,600.00	6,619,983.57	-481,383.57	107.8
210302	Түлш, халаалт	20,119,300.00	18,127,784.00	1,991,516.00	90.1
210303	Цэвэр, бохир ус	4,755,000.00	4,250,378.00	504,622.00	89.4
2104	Хангамж, бараа материалын зардал	40,521,100.00	34,010,570.00	6,510,530.00	83.9
210401	Бичиг хэрэг	14,362,700.00	11,895,750.00	2,466,950.00	82.8
210402	Тээвэр, шатахуун	9,399,600.00	9,399,600.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,847,800.00	4,391,570.00	456,230.00	90.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	951,000.00	951,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,960,000.00	7,372,650.00	3,587,350.00	67.3
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,544,000.00	33,537,500.00	6,500.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	2,999,800.00	200.00	100.0
210602	Тавилга	17,000,000.00	16,993,700.00	6,300.00	100.0
210604	Урсгал засвар	13,544,000.00	13,544,000.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	7,240,000.00	4,953,800.00	2,286,200.00	68.4
210702	Дотоод албан томилолт	7,240,000.00	4,953,800.00	2,286,200.00	68.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,849,800.00	9,440,653.00	5,409,147.00	63.6

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,409,000.00	8,000,000.00	5,409,000.00	59.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	189,000.00	188,853.00	147.00	99.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	1,200,000.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	7,800.00	7,800.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13594600.00	8586350.00	5,008,250.00	63.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,594,600.00	8,586,350.00	8,250.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	00.00	5,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2260000.00	1210000.00	1,050,000.00	53.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,260,000.00	1,210,000.00	1,050,000.00	53.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,260,000.00	1,210,000.00	1,050,000.00	53.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	737,706,300.00	737,706,200.00	100.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	737,706,300.00	737,706,200.00	100.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	737,706,300.00	737,706,200.00	100.00	100.0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			00.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23.00	21.00	02.00	91.3
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	11.00	01.00	91.7
620003	Үйлчлэх ажилтан	10.00	09.00	01.00	90.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Прокурорын газар /Аймгийн Прокурорын газар/ "Хууль тогтоох байгууллагын бодлогын үзэл санааг тууштай дэмжиж, хяналтын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, зон олны эрх, эрх чөлөө, эд баялаг, түүхт уламжлалыг сахин хамгаалж, хууль тогтоомжийг төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх" гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.



Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх,
- Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах,
- Прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх,
- Чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих,
- Прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Прокурорын газрын санхүүгийн үйл ажиллагаанд УЕПГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант оны 9 дүгээр сард 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалт хийж, цалингийн зардлаас татвар суутгаж Монголын хуульчдын холбоонд шилжүүлсэн, зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн бүртгэсэн, сургалтын зардлын үр дүнг тооцоогүй зэрэг зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

МУЕП-ын 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/125 дугаар тушаалаар МУПЕГ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,751.1 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	17,903.04	20,500.61	2597.57
Үндсэн хөрөнгө	814,061.29	835,214.84	21153.55
Нийт хөрөнгө	831,964.33	855,715.45	23751.12
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	831,964.33	855,715.45	23751.12
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	831,964.33	855,715.45	23,751.12

Бараа материалын дансны үлдэгдэл 20,500.6 мянган төгрөг болж 2,597.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 53,613.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 51,016.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 979,416.7 мянган төгрөг болж 5,437.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 19,694.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан, 26,671.1 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг МУПЕГ-аас, 8,600.0 мянган төгрөгийн лед дэлгэцийг аймгийн ИТХ-ын тогтоол болон МУЕП-ын тушаалаар орлогоор хүлээн зөвшөөрч, үнэ төлбөргүй хүлээн авсан, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжтой 68,875.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 23,490.0 мянган төгрөгөөр үнэлж орлого авсан болон ТӨБЗГ-ын даргын 2022 оны 262 дугаар тушаалаар 4,141.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 855,715.5 мянган төгрөг болж 23,751.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 766,429.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.


Төсвийн төслийн саналаас 106,369.0 мянган төгрөгөөр бууруулж /хангамж, бараа материалын зардлыг 9,604.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 12,322.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 12,555.0 мянган төгрөгөөр, тэтгэмжийн зардлыг 58,319.7 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна./ 660,061.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 77,645.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 10,387.1 мянган төгрөгөөр бууруулж,
- Хангамж, эд хогшил, урсгал засварын зардлыг 32,344.0 мянган төгрөгөөр,
- Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 22,462.7 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 13,594.6 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 10,621.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 737,706.2 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 737,706.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.



Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 700,356.7 мянган төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 36,299.5 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	727,446.4	691,146.7	36,299.7	95.0
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,260.0	1,210.0	1,050.0	53.5
3	Байцаан шийтгэх ажиллагаа	8,000.0	8,000.0	-	100.0
	Дүн	737,706.2	700,356.7	174.7	95.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130006401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах зөвлөмж өглөө.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/140 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 751,756.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,517.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор УЕПГ-ын 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 2/1579 тоот “Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай “ албан бичгийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Байгууллагын дулаан, цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч үр ашиггүй зардал гаргахгүй ажилласан,

- Худалдан авах бараа материалын төсвийг хийж, ерөнхий прокуророор хянуулан нэн шаардлагатай, зайлшгүй хэрэгцээт материалыг худалдаж авч зарцуулан, төсвийг зохистой удирдаж өр төлбөргүй тайлагнагдсан байна.

Гэвч аудитаар шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтыг зөрчиж тайлант оны 8 сард УБ хотод зохион байгуулагдсан бэсрэг наадамд 1,896.0 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан бөгөөд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдал намжсан, хэвийн байдалд шилжсэн хугацаанд буюу 2022 оны 9, 12 сард 2 удаагийн гүйлгээгээр бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 4,162.6 мянган төгрөгийг албан хаагчдын дархлаа дэмжих бүтээгдэхүүний төлбөрт зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Аймгийн Прокурорын газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	6,973.0	2	6,973.0	100
Нийт дүн	1	4,250.0	1	4,250.0	100

/мянган төгрөгөөр/



4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант жилийн төсөвт тусгагдаж, батлагдаагүй байхад МУЕП-ын 2022 оны А/118 дугаар тушаалын дагуу батлагдсан цалингийн зардлын 3.0 хувь болох 15,818.0 мянган төгрөгийг МУЕПГ-ын “Ахмадын сан-гийн дансанд шилжүүлсэн нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Энэ нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,058.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүйгээр зарцуулж, дараах ажил гүйлгээг гүйцэтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- “Ковид-19 “цар тахлын нөхцөл байдал намжсан, хэвийн байдалд шилжсэн хугацаанд буюу 2022 оны 9, 12 сард 2 удаагийн гүйлгээгээр бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 4,162.6 мянган төгрөгийг албан хаагчдын дархлаа дэмжих бүтээгдэхүүний төлбөрт зарцуулсан,


¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Тайлант оны 8 сард УБ хотод зохион байгуулагдсан бэсрэг наадамд 1,896.0 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан байна.

1.2 Шийдвэрлэлт : Батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй		4317143998	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулсан	1	6,058.6					1	6,058.6				
Дүн	1	6,058.6					1	6,058.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								